



ТАТВАРЫН БОДЛОГЫН ТОЙМ

ГЭРЭГЭ БОДЛОГЫН ХҮРЭЭЛЭН

Боловсруулсан:

А.Батпүрэв, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн
Эдийн засгийн бодлогын зөвлөх, PhD

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын татварын бодлогын өнөөгийн гол гажуудал нь татварын хувь хэмжээ өндөртөө бус, татварын ачаалал шударга бус хуваарилагдаж байгаад оршиж байна. Өнөөгийн системд цалинтай иргэн ба ажил олгогч хамтдаа тухайн ажилтны цалингийн 1/3-тэй дүйцэхүйц хэмжээний татвар, НДШ-ийг албан журмын дагуу төрд төлж байна. Үүний зэрэгцээ төрд бүртгэлтэй, албан ёсны эдийн засаг дахь бизнесүүдийн хувьд бүх төрлийн татвараас гадна шимтгэл, төлбөр, хураамж, алданги, торгууль, зөвшөөрлийн давхар дарамт дор ажиллаж байна. Гэтэл түрээсийн, хөрөнгийн, хувиараа эрхлэх үйл ажиллагаа зэрэг орлого олдог ч төрд бүртгэгддэггүй, татвар төлдөггүй үйл ажиллагаанууд нь далд эдийн засгийн томоохон хэсгийг бүрдүүлж, нийгмийн өмнө хүлээх үүргээ дан ганц албан секторт үүрүүлж байна.

Түүнчлэн уул уурхайн орлого сайн үед төсөв тэлж, муудах үед төр төсвийн алдагдлаа мөн л албан сектор дахь нөгөө л иргэн, бизнесээс илүү их татвар авах замаар нөхөх байдал давтагдаж байна. Иймээс татварын шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ дан ганц татварын хувь хэмжээнд чиглэх бус, албан бус эдийн засгийг ил болгох буюу албан секторыг тэлэх, төсвийн сахилга батыг сайжруулах, төрийн өмчийн компаниудын үр ашгийг нэмэгдүүлэх эсхүл хувьчлах зэрэг татварын суурь, бизнесийн орчны шинэчлэлийг хамтад нь авч үзэх шаардлагатай юм.

1. НӨХЦӨЛ БАЙДАЛ

Асуудал 1. ХХОАТ-ын ачаалал цалинтай иргэд дээр төвлөрсөн.

ХХОАТ-ын тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгө борлуулсны орлого болон бусад орлогыг татварын суурьт хамруулахаар заасан боловч бодит хэрэгжилт дээр ХХОАТ-ын орлогын 80-аас дээш хувийг цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого бүрдүүлж, үйл ажиллагааны орлогоос төлсөн татвар 4-6 хувь орчим байна. Цалин хөлс ба түүнтэй адилтгах хөдөлмөрийн орлогоос 10, 15, 20 хувиар шууд суутган төлдөг бол бусад орлогын хувьд үйл ажиллагааны орлого 1%, хөрөнгө борлуулсны орлого 2%, үнэт цаасны ногдол ашиг 5% (хөнгөлөлтийн хугацаанд), Засгийн газрын бондын өгөөж 0% зэргээр бага хувь хэмжээтэй төдийгүй татварын хамрагдалт нь бодит хэмжээнээс бага байна.

Бодлогын дүгнэлт: Монгол Улс “өргөн суурьтай ХХОАТ”-тай мэт боловч бодит хэрэгжилт дээрээ зөвхөн “цалингийн татварын систем” болсон байна.

Асуудал 2. Бага орлоготой өрхөд шууд татварын дарамт өндөр байна.

Дэлхийн банкны 2025 оны Mongolia Public Finance Review тайланд Монголын ХХОАТ-т суурь орлогын чөлөөлөлт хангалтгүй байгаа нь бага орлоготой татвар төлөгчдөд харьцангуй өндөр дарамт үүсгэж, хамгийн ядуу 10 хувийн (өрх) хувьд шууд татвар нь татварын өмнөх орлогын бараг 8 хувьд хүрч байгааг тэмдэглэсэн. Үүний зэрэгцээ цалингаар амьдардаг өрхүүдийн болон дундаж давхаргынхны бодит орлого инфляцын өсөлт, орон сууцны зээл, түрээс, хүнс, шатахуун, боловсрол, эрүүл мэндийн зардал, хотын татвар, тээврийн хэрэгслийн татвар, зам ашигласны төлбөр, бусад хураамжийн нийлбэр нөлөөгөөр буурч байгаа үед ХХОАТ нэмэлт дарамт үзүүлж байна.

Бодлогын дүгнэлт: ХХОАТ-ын өнөөгийн бүтэц нь дундаж давхарга төдийгүй, албан хөдөлмөр эрхэлж буй бага орлоготой өрхөд дарамт учруулж байна.

Асуудал 3. ААНОАТ-ын шатлал бизнес өсөж томрох сэдлийг сулруулж байна.

Дэлхийн банкны үнэлгээгээр Монголын ААНОАТ-ын олон шатлалтай бүтэц нь компанийн хэмжээнд гажуудал үүсгэж, бизнесийн шийдвэр, хөрөнгө оруулалт, өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Жижиг татвар төлөгчид хялбаршуулсан 1 хувийн горим ашиглах боломжтой ч дунд бизнес томрох үед татварын огцом дарамт үүсэх нөхцөлтэй байна. Улмаар Засгийн газраас өргөн барьсан шинэ төсөл батлагдвал 15 хувиас 25 хувийн татварын шатлалд шилжихгүйн тулд ААН-үүд дунд хэмжээнд үлдэх эрсдэл нэмэгдэх юм. Мөн бизнесийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашгийг үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, шинэ салбар нээх зэргээр дахин хөрөнгө оруулах, эсвэл групп дотор толгой компанид ногдол ашиг хэлбэрээр төвлөрүүлж дараагийн хөрөнгө оруулалтад ашиглах үед татварыг давхардуулан төлдөг.

Бодлогын дүгнэлт: Жижиг бизнесийг хялбаршуулсан горимоор дэмжих нь зөв боловч дунд бизнес томрох үед татварын огцом дарамт үүсвэл компаниуд томрохоос зайлсхийх, хиймлээр хуваагдах эрсдэлтэй. Мөн давхар татварын нөлөө нь хөрөнгө оруулалт, капиталын хуримтлалыг дэмжих бус шийтгэж байна.

Асуудал 4. Гарааны бизнес, инновацийн хөрөнгө оруулалтыг дэмжих татварын орчин хангалттай бүрдээгүй.

Гарааны бизнес нь эхний жилүүдэд ашиггүй, барьцаа хөрөнгө багатай, судалгаа-хөгжүүлэлт болон хүмүүн капиталд их хэмжээний зардал гаргадаг, хөрөнгө оруулагчдын зүгээс энэ төрлийн бизнест хөрөнгө оруулахад өндөр эрсдэл хүлээдэг зэрэг онцлогтой. Гэтэл энэ төрлийн бизнест төрөөс бодитой дэмжлэг үзүүлдэггүй, ялангуяа татварын бодлогоор хангалттай дэмжлэг үзүүлэхгүй байна.

Бодлогын дүгнэлт: Гарааны бизнес, инновацийн хөрөнгө оруулалтыг татварын бодлогоор дэмжих, хувийн хөрөнгө оруулагчдыг дэмжих татварын хөшүүрэг бий болгох шаардлагатай байна.

Асуудал 5. ЖДҮ-ийн бодит дарамт нь санхүүгийн бүртгэл тайлагнал

Ихэнх ЖДҮ-д татварын асуудал нь “хэдэн хувь төлөх вэ?” гэхээс илүүтэй “яаж зөв тайлагнах вэ, хэдэн тайлан өгөх вэ, ямар алдаа гаргавал торгуулах вэ?” гэдэг асуултууд захиргааны дарамт болж хувирдаг.

Бодлогын дүгнэлт: ЖДҮ-үүдэд татвараа төлөхөөс илүүтэй санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагаа болдог

Асуудал 6. НӨАТ-ын систем үр дүнтэй боловч бизнесийн мөнгөн урсгалд дарамт үүсгэж байна.

НӨАТ-ын и-баримтын систем нь татварын бүртгэл, хяналтад чухал ахиц авчирсан. Гэвч ААН-үүдийн НӨАТ-ын илүү төлөлт, буцаан олголтын удаашрал, тодорхой бус байдал нь бизнесийн мөнгөн урсгалд шууд дарамт үүсгэдэг.

Бодлогын дүгнэлт: НӨАТ-ын и-баримтын систем, бага хэмжээний урамшууллын системийг хадгалах нь зүйтэй. Харин буцаан олголт, илүү төлөлттэй холбоотой мөнгөн урсгалын асуудлыг шийдэх шаардлагатай.

Асуудал 7. Төсвийн орлого нэг салбараас хэт хамааралтай буюу жигд бус байна.

2020-2023 онд Монгол Улсын төсвийн орлого ДНБ-ий дунджаар 32 хувь байсан бөгөөд түүний 1/4 орчмыг уул уурхайн салбараас бүрдүүлсэн. Мөн уул уурхайн салбар ААНОАТ-ын ойролцоогоор тал, НӨАТ болон ХХОАТ-ын тус бүр 15 орчим хувийг бүрдүүлж байсныг Дэлхийн банк тэмдэглэсэн. 2004–2023 онд ашигт малтмалын орлогоос 97 центээс илүүг нь хэрэглэж, 3 центээс бага хэсгийг хуримтлуулсан гэж дүгнэсэн. Өөрөөр хэлбэл төсвийн орлого бүрдүүлэлт уул уурхайн салбараас хэт хамааралтай байгаа нь өндөртэй савалгаатай таваарын зах зээлийг дагаж төсвийн орлого хэлбэлзэх, төсвийн зардлаа нөхөж чадахгүй байдалд хүрч байна.

Үүнтэй зэрэгцээд төрөөс олгож буй татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь төсөвт шууд зарлага болж тусдаггүй ч төрөөс олгож буй татаас мөн юм. Иймд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашгийг сайжруулах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх буюу нэг салбараас хэт хамааралтай байдлыг бууруулах чиглэлд ажиллах шаардлагатай байна.

Бодлогын дүгнэлт: Татварын шинэчлэл дан ганц хувь хэмжээний асуудал биш бөгөөд төсвийн сахилга батыг сайжруулах, татварын орлогын нэг салбараас хэт хамааралтай байдлыг багасгах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

УИХ-ЫН
СУДАЛГААНЫ САН

3. БАРУУН-ТӨВИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ҮҮДНЭЭС ТАТВАРТ ХАНДАХ ЗАРЧМУУД

Зарчим 1. Татварын шударга, жигд байдал ба өргөн суурь: цөөн төлөгч дээр төвлөрсөн ачааллыг бууруулах

Монгол Улсын татварын бодлогын гол асуудал нь зөвхөн хувь хэмжээ өндөр эсэхэд бус, татварын ачаалал цөөн, ил тод, албан ёсны татвар төлөгч дээр төвлөрч байгаагийн зэрэгцээ нэг салбараас хэт хамааралтай байгаад оршиж байна. Баруун-төвийн татварын бодлогын зарчим нь татварын хувь хэмжээг нэмэх бус, татварын суурийг өргөтгөх явдал юм. Илүү олон орлогын эх үүсвэрийг шударгаар бүртгэж, татварт хамруулснаар нэг татвар төлөгчид ногдох ачааллыг бууруулахаас гадна төсвийн орлогын нэг салбараас хэт хамааралтай байдлыг багасгах боломжтой.

Зарчим 2. Хөдөлмөр, ур чадвар, хуримтлал, бизнесийн өсөлтийг шийтгэхгүй байх

Татварын бодлого нь хөдөлмөрлөх, илүү бүтээмжтэй ажиллах, ур чадвараа дээшлүүлэх, хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулах, бизнесээ томруулах сэдлийг бууруулж болохгүй. Илүү орлого олж байгаа бүх иргэнийг автоматаар “илүү татвар төлөх ёстой бүлэг” гэж үзэх нь дундаж давхарга, мэргэжилтэн, инженер, эмч, багш, менежер, өндөр ур чадвартай хувийн хэвшлийн ажилтнуудад буруу дохио өгдөг. Монгол Улсад өндөр бүтээмжтэй хөдөлмөр, мэргэжлийн ур чадвар, менежментийн чадавх дутагдалтай хэвээр байгаа нөхцөлд татварын бодлого эдгээр хүмүүсийг шийтгэх бус, урамшуулах ёстой.

Зарчим 3. Төрийн үрэлгэн зардлыг татвар нэмэх замаар нөхөхгүй байх

Татварын аливаа шинэчлэл нь төсвийн сахилга бат, төрийн зардлын үр ашиг, төрийн өмчит компаниудын алдагдал, далд өр төлбөр, төсвийн гадуурх санхүүжилтийн асуудлаас салангид яригдах боломжгүй. Ардчилсан намын үзэл баримтлалын хувьд татварын бодлого нь төрийг томруулах хэрэгсэл бус, хязгаарлагдмал, хариуцлагатай, ил тод төрийг санхүүжүүлэх хэрэгсэл байх ёстой. Татвар нэмэхээс өмнө төр өөрөө зардлын сахилга баттай болох ёстой.

Зарчим 4. Энгийн, тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой татварын орчин

Татварын тогтолцоо ойлгомжгүй, давхардсан байх нь бизнесийн байгууллагуудад очих татварын дарамтыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн олон тайлантай, мэргэжлийн нягтлан бодогчгүйгээр биелүүлэхэд хэцүү байх тусам жижиг бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэгч, шинэ бизнес эрхлэгчдийг албан бус эдийн засаг руу түлхдэг. Татвар төлөх нь өөрөө бизнес эрхлэхээс илүү төвөгтэй байж болохгүй. Мөн татварын тогтвортой байдлыг хангах замаар төр болон эдийн засгийн оролцогчдын хооронд итгэлцэл, ил тод байдлыг бий болгож, эдгээр оролцогчдод үйл ажиллагаагаа урт хугацаагаар төлөвлөх, эрсдэлээ тооцоолох боломжийг олгодог байх хэрэгтэй.

Зарчим 5. Гарааны бизнес, инновацын хөрөнгө оруулалтыг дэмжих татварын орчин

Гарааны бизнесүүд нь эхэн үедээ хөгжүүлэлтэд өндөр зардал гаргадаг тул алдагдалтай ажилладаг ба тухайн бизнес нь амжилттай болох магадлал тодорхойгүй тул хөрөнгө оруулагчдын хувьд эрсдэл өндөртэй байдаг. Иймд гарааны бизнесүүдийн эхний жилүүдэд төрөөс тавигддаг шаардлага, татвар, хураамж, зөвшөөрөл зэргээс хөнгөлөх, чөлөөлөх, хойшлуулах бодлогын дэмжлэг үзүүлэх, хувийн хөрөнгө оруулагчдыг дэмжих татварын хөшүүрэг бий болгох зэрэг татварын цогц бодлого боловсруулах шаардлагатай.

4. САНАЛ БОЛГОЖ БОЛОХ ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН БАГЦ

Шинэчлэлийн чиглэл 1. Цалин, хөдөлмөрийн орлогын ХХОАТ-ыг бага, жигд, хөдөлмөрт ээлтэй болгох, татварын хөнгөлөлт, буцаалтыг өрхийн нөхцөл байдалтай уялдуулах

Монгол Улсын татварын бодлогын гол асуудал нь зөвхөн хувь хэмжээ өндөр эсэхэд бус, татварын ачаалал цөөн, ил тод, албан ёсны татвар төлөгч дээр төвлөрч байгаагийн зэрэгцээ нэг салбараас хэт хамааралтай байгаад оршиж байна. Баруун-төвийн татварын бодлогын зарчим нь татварын хувь хэмжээг нэмэх бус, татварын суурийг өргөтгөх явдал юм. Илүү олон орлогын эх үүсвэрийг шударгаар бүртгэж, татварт хамруулснаар нэг татвар төлөгчид ногдох ачааллыг бууруулахаас гадна төсвийн орлогын нэг салбараас хэт хамааралтай байдлыг багасгах боломжтой.

Үндэслэл: Монгол Улсын ХХОАТ-ын бодит ачаалал цалинтай иргэд дээр төвлөрч байна. Түүнчлэн ХХОАТ-д суурь орлогын чөлөөлөлт хангалтгүй байгаа нь бага орлоготой татвар төлөгчдөд харьцангуй өндөр дарамт үүсгэж байгаагийн зэрэгцээ ХХОАТ-ын одоогийн бүтэц нь цалингаар амьдардаг өрхүүдийн болон дундаж давхаргынхны буурч буй бодит орлогод давхар дарамт үзүүлж байна.

Мөн ХХОАТ-ын одоогийн шаталсан бүтэц нь өндөр ур чадвартай мэргэжилтэн, менежер, хувийн хэвшлийн бүтээмжтэй ажилтнуудыг “илүү цалин авсан”-ы төлөө өндөр татварын ангилалд оруулж, хүний капитал, ур чадвар, бүтээмжийг шийтгэх эрсдэлтэй.

Санал:

- Цалин, түүнтэй адилтгах хөдөлмөрийн орлогын ХХОАТ-ын хувь хэмжээг бага, жигд болгох;
- Өндөр ур чадвартай ажилтныг шийтгэдэг шаталсан татварын дарамтыг бууруулах;
- Цаашид өрхийн нөхцөл байдалд суурилсан хөнгөлөлт, буцаалтын систем рүү шилжих. Иргэн нийт орлогоо хялбар горимоор тайлагнаж, гэр бүлийн байдал, хүүхдийн тоо, орон сууцны нөхцөл, ипотекийн зээл, боловсрол, эрүүл мэндийн зайлшгүй зардал зэрэг хүчин зүйлийг харгалзан татварын буцаалт, хөнгөлөлт авах боломжтой системийг үе шаттай бүрдүүлэх;
- ХХОАТ болон иргэний нийгмийн хөгжлийг уялдуулах бодлогын шийдэл боловсруулах.

Ийнхүү ажил хийж буй хүний гар дээр ирэх орлогыг нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэх, ур чадвараа дээшлүүлэх сэдлийг хадгалсан албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого нь халамжийн бодлогоос илүү үр ашигтай.

Шинэчлэлийн чиглэл 2. ААНОАТ нь өсөлт, хөрөнгө оруулалтыг шийтгэдэг тогтолцоог засах

Үндэслэл: Одоогийн ААНОАТ-ын бүтэц нь бизнесийн хэмжээ, ашиг, орлогын түвшнээс хамаарч татварын дарамт огцом өсөх эрсдэлтэй. Компани томрох тусам татварын дарамт огцом нэмэгдэнэ гэж үзвэл бизнесүүд хиймлээр жижиг хэвээр үлдэх, хэд хэдэн компани болгон хуваагдах, орлогоо бүрэн тайлагнахгүй байх, хөрөнгө оруулалтаа хойшлуулах, ашгаа албан бусаар гаргаж авах сэдэлтэй болдог.

Мөн бизнесийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашгийг дахин хөрөнгө оруулах, эсвэл групп дотор толгой компани ногдол ашгаа төвлөрүүлж дараагийн хөрөнгө оруулалтад ашиглах үед татварыг давхардуулан төлдөг нь бизнесүүдэд очих татварын дарамтыг нэмэгдүүлж байна.

Санал:

- ААНОАТ-ын огцом шатлал, босгыг бууруулж цаашид жигд болгох;
- Жижиг бизнесийн 1 хувийн хялбаршуулсан горимыг хадгалах;
- Жижиг бизнесээс дунд бизнес рүү шилжих үед татвар, тайлан, НӨАТ, НДШ, аудит, хяналтын дарамт огцом нэмэгддэг байдлыг зөөлрүүлэх;
- Дахин хөрөнгө оруулсан ашгийг дэмжих татварын зохицуулалт хийх;
- Нэг эцсийн өмчлөгчтэй, ил тод тайлагналтай, бодит үйл ажиллагаа явуулдаг группүүдийн хувьд дотоод ногдол ашиг, дахин хөрөнгө оруулалтын урсгалд давхар татвар ногдуулахгүй байх зохицуулалтыг олон улсын жишигтэй харьцуулан судалж хэрэгжүүлэх.

ААНОАТ-ын зорилго нь бизнесийн өсөлтийг сааруулах биш, ашигтай, ил тод, өрсөлдөх чадвартай компаниудыг дэмжих явдал байх ёстой.

Шинэчлэлийн чиглэл 3. Гарааны бизнес, инновац, венчур хөрөнгө оруулалтыг дэмжих татварын шинэчлэл

Үндэслэл:

Гарааны бизнес, инновацын үйл ажиллагаа, түүнд хөрөнгө оруулах мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, дэмжих татварын орчин бүрдээгүй байна. Өөрөөр хэлбэл энэ төрлийн бизнесүүдийг татвараар хангалттай дэмждэггүй, хувийн хөрөнгө оруулагчдын эрсдэлийг татварын бодлогоор хуваалцах механизм сул (Angel investor, венчур сан, стратегийн хөрөнгө оруулагч гарааны бизнест хөрөнгө оруулахад өндөр эрсдэл үүрдэг), ажилтны хувьцаа, опционы татварын орчин тодорхой бус, судалгаа-хөгжүүлэлт, технологийн хөрөнгө оруулалтад тусгай татварын хөшүүрэг сул, венчур сангийн татварын бүтэц тодорхой бус байна.

Санал:

- Баталгаажсан гарааны бизнест хийсэн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг ХХОАТ эсвэл ААНОАТ-аас чөлөөлөх¹;
- ESOP буюу ажилтны хувьцаа, опционы татварын тусгай горим нэвтрүүлэх²;
- Судалгаа-хөгжүүлэлт, инновацын зардалд татварын кредит эсвэл нэмэгдүүлсэн хасалт олгох³;
- Эхний жилүүдийн алдагдлыг урт хугацаанд шилжүүлэн тооцох боломжийг сайжруулах⁴;
- Гарааны бизнест оруулсан хөрөнгө оруулалтын алдагдлыг татварын зорилгоор хүлээн зөвшөөрөх⁵;

Шинэчлэлийн чиглэл 4. ЖДҮ-д зориулсан “нэг цонхны татварын горим” бий болгох

Үндэслэл: НӨАТ, НДШ, суутган татвар, олон төрлийн тайлан, зөвшөөрөл, давхардсан шалгалт, торгууль, хураамж, нягтлан бодох бүртгэлийн зардал нийлээд жижиг бизнесийн хувьд том дарамт болдог.

Санал:

- ЖДҮ-д зориулсан нэг хуудас цахим тайлан нэвтрүүлэх;
- Жижиг бизнесүүд борлуулалт, үндсэн зардал, ажилтны тоо, НДШ, төлөх татвараа нэг цонхны системээр тайлагнадаг байх;
- НӨАТ, ААНОАТ, суутган татварын тайланг нэгтгэсэн жижиг бизнесийн интерфэйс бий болгох;
- Төр өөрт байгаа мэдээллээр тайланг урьдчилан бөглөж, бизнес зөвхөн баталгаажуулдаг хэлбэр рүү шилжих;

Татварын системийн зорилго нь бизнесийг торгох биш, сайн дураар дагаж мөрдөхөд туслах байх ёстой.

[1] Нэг хөрөнгө оруулагчид ногдох жилийн дээд хязгаар тогтоох, инновацын салбарыг тодорхойлох, хөрөнгө оруулалтыг дор хаяж 3–5 жил хадгалах нөхцөл тавих, зөвхөн шинээр гаргасан хамааралгүй этгээдүүдийн хувьцаа, хөрвөх зээл, SAFE (ирээдүйн хувь эзэмшлийн хялбар хэлцэл) хэлбэрийн бодит хөрөнгө оруулалтад хөнгөлөлт олгох.

[2] Ажилтанд олгосон опционд олгох үед нь бус, бодитоор хувьцаа борлуулах эсвэл мөнгөн ашиг хүртэх үед нь татвар ногдуулах, ESOP-ийн орлогыг хөдөлмөрийн орлого бус, тодорхой нөхцөл хангаж байвал капиталын ашиг хэлбэрээр татвар тооцох боломжийг судлах, ажилтан хувьцаагаа тодорхой хугацаанд хадгалсан бол хөнгөлөлттэй татварын хувь хэрэглэх.

[3] R&D зардлыг ердийн зардлаас өндөр коэффициентоор хасах буюу super deduction нэвтрүүлэх, ашиггүй байгаа гарааны компанид татварын кредитийг дараагийн жилүүдэд шилжүүлэн ашиглах боломж олгох, программ хангамж, патент, технологийн лиценз, туршилтын тоног төхөөрөмж, дата дэд бүтэц зэрэг зардлыг хамруулах.

[4] Гарааны болон инновацын компаниудад алдагдлыг шилжүүлэн тооцох хугацааг уртасгах, Ownership change буюу хөрөнгө оруулагч орж ирэх үед алдагдал шилжүүлэх эрхийг бүрэн алдахгүй байх зохицуулалт хийх.

[5] Хамаарал бүхий этгээдийн хиймэл алдагдлыг хасахгүй байх, хасах дүнгийн дээд хязгаар, хугацаа тогтоох.

Шинэчлэлийн чиглэл 5. НӨАТ-ын буцаан олголтыг автомат, хугацаатай, бизнесийн мөнгөн урсгалд ээлтэй болгох

Үндэслэл: НӨАТ нь төсвийн орлого бүрдүүлэх, гүйлгээг ил тод болгох, далд эдийн засгийг бууруулах чухал хэрэгсэл. Гэвч хөрөнгө оруулалт хийж байгаа, тоног төхөөрөмж худалдан авч байгаа, өсөлтийн шатанд байгаа бизнесүүдийн хувьд НӨАТ-ыг заавал эхэнд нь төлдөг, буцаан олголт удааширдаг нь эргэлтийн хөрөнгийг царцааж, зээлийн хэрэгцээг нэмэгдүүлж, санхүүгийн зардлыг өсгөдөг.

Санал:

- НӨАТ-ын хувь хэмжээг оновчтой тогтоох;
- НӨАТ-ын буцаан төлөлтийг олгох хуулийн тодорхой хугацаа тогтоох;
- Эрсдэл багатай татвар төлөгчид автомат буцаан олголт хийх;
- Хөрөнгө оруулалтын НӨАТ-ыг хурдан буцаах тусгай горим бий болгох.

Шинэчлэлийн чиглэл 6. Татварын бүх хөнгөлөлт, чөлөөлөлтийг “татварын зардлын тайлан”-гаар ил тод болгох

Үндэслэл: Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь хөрөнгө оруулалт, бүс нутгийн хөгжил, салбарын бодлогыг дэмжих зохицуулалтын зорилготой байдаг. Гэвч бодит байдал дээр зарим хөнгөлөлт нь тодорхой салбар, бүлэг, компанид олгосон далд давуу эрх, лобби, улс төрийн татаас болж хувирдаг. Иймд төсөв дээр шууд “зарлага” гэж харагдахгүй боловч төрийн зардлууд болох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулах замаар татварын орлогын жигд бус байдлыг бууруулах шаардлагатай байна.

Санал:

- Жил бүрийн төсөвтэй хамт татварын зардлын тайланг олон нийтэд нээлттэй танилцуулж УИХ-д хэлэлцүүлэх;
- Хөнгөлөлт бүрт бодлогын зорилго, хугацаа, үнэлгээний шалгуур тогтоох. “Хугацаагүй хөнгөлөлт” байх ёсгүй. Шинээр олгох аливаа хөнгөлөлт тодорхой хугацаатай, үр дүнгийн шалгууртай байх ёстой;
- Татварын хөнгөлөлтийг “халамжийн бизнес” болгохоос сэргийлэх;

АШИГЛАСАН ҮНДСЭН ЭХ СУРВАЛЖ

- World Bank. Mongolia Public Finance Review 2025.
- А.Батпүрэв, ХХОАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын нөлөөллийн үнэлгээ, 2025.
- Нээлттэй нийгэм форум, Монгол Улсын төрөөс төсөв болон төрийн өмчит аж ахуйн нэгжээр дамжуулан эдийн засагт оролцож буй оролцооны түвшний харьцуулсан судалгаа, 2025.
- Татварын холбогдох хууль тогтоомжууд
- Монгол Улсын төсөв, татвар, уул уурхайн орлогын талаарх Дэлхийн банк, IMF болон үндэсний судалгааны материалууд.



Гэрэгэ бодлогын хүрээлэн нь бодлого боловсруулахад зөвлөх, судалгаа хийх, намын гишүүдийг сургаж бэлтгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үүрэг бүхий Ардчилсан намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Холбоо барих

- 📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу-1, Ардчилсан намын байр.
- ✉ info@geregethinktank.mn
- 📍 Гэрэгэ бодлогын хүрээлэн / Gerege think tank